



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.05.23 № 01/3533  
танай \_\_\_\_\_ -НЫ № \_\_\_\_\_ -Т

Төсвийн хөрөнгө оруулалтын  
тухай

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 1141 төсөл, арга хэмжээний 2,974.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 2023 оны 05 дугаар сарын 19-ний байдлаар 457.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 15.4%-тай байгаа бөгөөд үүний 155.9 тэрбум төгрөг нь барилгын материалын үнийн өсөлтийн санхүүжилт байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж, 13.1.2-т "энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох" гэж тус тус заасны дагуу 2023 онд батлагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд шинээр гэрээ байгуулах төсөл, арга хэмжээ нь 2023 оны 05 дугаар сарын 31-ний дотор гэрээ байгуулагдсан байх зохицуулалттай байна.

Шинээр гэрээ байгуулах төсөл, арга хэмжээ нь хууль тогтоомжийн хүрээнд дээрх хугацаанд зохион байгуулагдаж гэрээ байгуулагдаагүй тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилт олгох боломжгүй гэдгийг анхаарч ажиллах нь зүйтэй байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн мэдээг хавсаргав.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

Сангийн сайдын 2023 оны 5 дугаар сарын 23 -ны өдрийн 01/3523 тоот албан бичгийн хавсралт



**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн санхүүжилтийн мэдээ**

2023.05.19-ний байдлаар, сая төгрөгөөр

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Үүнээс 2023 онд дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Нийт гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Үлдэгдэл санхүүжилт
1	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	3	2	10,345.7	7,543.8	366.1	4.85%	7,177.8
2	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	2	1	55,634.1	43,193.8	344.1	0.80%	42,849.7
3	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	31	26	84,828.5	23,091.1	4,949.8	21.44%	18,141.3
4	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	24	24	48,769.3	18,492.1	1,669.1	9.03%	16,823.0
5	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	6	6	24,031.6	11,865.6	1,532.6	12.92%	10,333.0
6	САНГИЙН САЙД	6	3	494,518.5	245,402.0	13,369.5	5.45%	232,032.5
7	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	24	20	88,145.6	41,557.7	11,042.8	26.57%	30,514.9
8	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	33	23	132,989.6	36,841.3	8,243.4	22.38%	28,597.8
9	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	169	126	974,575.9	345,152.5	50,852.5	14.73%	294,300.1
10	БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	399	303	1,634,389.2	529,281.5	113,174.0	21.38%	416,107.5
11	СОЁЛЫН САЙД	77	66	546,000.8	144,237.3	26,685.4	18.50%	117,552.0
12	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	120	102	1,577,015.7	408,821.9	48,567.8	11.88%	360,254.2
13	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	47	36	138,936.7	74,672.5	10,854.3	14.54%	63,818.3
14	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	42	25	482,439.0	168,999.2	22,062.7	13.05%	146,936.6
15	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	106	79	469,278.3	172,118.7	34,416.3	20.00%	137,702.4
16	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4	4	27,644.4	13,093.9	10,326.5	78.86%	2,767.4
17	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1	1	572.5	458.0	-	0.00%	458.0
18	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	5	4	24,546.0	21,625.9	-	0.00%	21,625.9
19	МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	35	29	162,061.6	48,823.2	16,800.9	34.41%	32,022.3
20	МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	3	1	408,523.1	339,743.2	81,666.0	24.04%	258,077.2
<b>УЛСЫН ТӨСВИЙН ДҮН</b>		<b>1137</b>	<b>881</b>	<b>7,385,246.2</b>	<b>2,695,015.3</b>	<b>456,923.7</b>	<b>16.95%</b>	<b>2,238,091.6</b>
<b>КОНЦЕССЫН ДҮН</b>		<b>4</b>	<b>4</b>	<b>541,524.7</b>	<b>279,590.4</b>	<b>547.0</b>	<b>0.20%</b>	<b>279,043.4</b>
<b>НИЙТ</b>		<b>1141</b>	<b>885</b>	<b>7,926,770.9</b>	<b>2,974,605.7</b>	<b>457,470.7</b>	<b>15.38%</b>	<b>2,517,135.0</b>